



**"НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН
АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ
БУУРУУЛАХ НЭГДСЭН ТӨСӨЛ
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ" УТҮГ**

Нийслэлийн Нутгийн захиргааны цогцолбор Б блок,
Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976) 7000 1936, 7000 1937
Цахим шуудан: project@ulaanbaatar.mn

2024.11.20 № 1/602

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн №А/1193 дугаартай захирамжаар байгуулсан Үнэлгээний хорооны 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зарласан ЗТХЯ/20240101127 дугаартай “Шинэ тойрог авто зам” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/ тендер шалгаруулалтад сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгатай холбоотой тус Үнэлгээний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн №01 дугаартай тодруулгуудыг хүлээн авч, хянаж үзлээ. Үүнтэй холбогдуулан дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	ТББ-ийн ШТЗ 19.1-д Төслийн менежер (Төслийн удирдагч), Төслийн зохицуулагч нар нь Хот төлөвлөлтийн чиглэлээр (хүрээлэн буй орчин, төлөвлөлтийн аль нэг) болон Хотын хөгжлийн чиглэлээр (хүрээлэн буй орчин, төлөвлөлтийн аль нэг) болон докторын зэрэгтэй байх шаардлага тавьсан. Дээрх эрдмийн зэргийн шаардлагад “PhD in Transport Planning” буюу Тээврийн төлөвлөлтийн докторын зэрэг нийцэх эсэхийг баталгаажуулж өгнө үү.	ТББ-ийн ТШЗ 19.1-д заасан Төслийн менежер болон Төслийн зохицуулагчийн мэргэжлийн шаардлага: Төслийн менежер, зохицуулагч нар нь Хотын хөгжлийн чиглэлээр буюу хүрээлэн буй орчин, хот төлөвлөлтийн чиглэлээр мэргэшсэн, докторын зэрэгтэй байх нь ТББ-д заагдсан шаардлага юм. Тиймээс Тээврийн төлөвлөлтийн чиглэлээр докторын зэрэгтэй мэргэжилтэн нь энэхүү шаардлагад нийцэхгүй.
2	ТББ-ийн Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-ийн 11-т “Хотын хүрээлэн буй орчны мэргэжилтэн”-ийн боловсрол, мэргэжлийн	ТББ-ийн ТШЗ 19.1-д заасан Хотын хүрээлэн буй орчны мэргэжилтний боловсролын шаардлага:

<p>ур чадварын шаардлагад хотын байгаль орчин, хүрээлэн буй орчны чиглэлээр доктор зэрэгтэй байх гэж заасан байна. Тус албан тушаалд Хотын байгаль орчин, хүрээлэн буй орчны чиглэлээр бакалавр зэрэгтэй мэргэжилтэн санал болговол шаардлага хангасанд тооцох эсэхийг баталгаажуулж өгнө үү.</p>	<p>Бакалаврын зэрэгтэй мэргэжилтэн санал болгох тохиолдолд энэ нь шаардлага хангаагүйд тооцогдох бөгөөд докторын зэрэгтэй мэргэжилтэн ажиллуулах шаардлагатай.</p>
---	--

Хувийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт